

Банкуудын зээлийн тайлан

2017 оны 6 дугаар сар

Хураангуй мэдээлэл:


- Банкуудын **нийт зээлийн үлдэгдэл 2017 оны 6 дугаар сарын байдлаар 12.8 их наяд төгрөгт** хүрснээс 79.7 хувь төгрөгийн зээл байна.
- Тайлант сард шинээр **1 их наяд 389 тэрбум төгрөгийн зээл олгогдсоны 74.4 хувь нь төгрөгийн зээл байна. Харин 1 их наяд 140 тэрбум төгрөгийн зээл төлөгдөв.**
- **Нийт зээлийн 6.2 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 8.8 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна.** Усан хангамж; бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын чанаргүй зээл 48.0 хувь, уул уурхай олборлолт 25.7 хувь, боловсруулах үйлдвэрийнх 17.0 хувь, худалдааны салбарынх 10.4 хувьтай байна.
- **Нийт хэвийн зээлийн үлдэгдлийн 61.3 хувийг 1-5 жилийн хугацаатай зээл, 21.1 хувийг 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээл, 17.6 хувийг 1 жил хүртэлх хугацаатай зээл бүрдүүлж байна. Харин нийт олгосон зээлийн 39 хувь нь 1 жил хүртэл хугацаатай, 49.5 хувь нь 1-5 жил хүртэл хугацаатай, 11.5 хувь нь 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай олгогджээ.**
- **Нийт зээлийн үлдэгдлийн 51.9 хувийг хувийн хэвшилд, 47.1 хувийг иргэдэд олгосон зээл эзэлж байна. Тухайн сард олгосон зээл өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар буурснаас хувийн хэвшилд олгосон зээл 23.2 хувиар буурч иргэдэд олгосон зээл 30.4 хувиар өсчээ.**
- **Тухайн сард ЖДҮ эрхлэх зориулалтаар ААН-үүдэд 144.3 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 17.7 хувийн хүүтэй, 26.3 сарын хугацаатай, иргэдэд 141.1 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 23.1 хувийн хүүтэй, 20.5 сарын хугацаатай олгожээ.**

Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оноос 7.2 хувиар өсч 12 их наяд 805.4 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнээс татан буугдсан¹ банкуудын зээлийн үлдэгдлийг хасч тооцвол 12 их наяд 607.9 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос 7.6 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин банкуудаас Монголын Ипотекийн Корпорацид шилжүүлсэн² багцыг оруулж тооцвол нийт зээлийн үлдэгдэл 15 их наяд 257 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос 7.7 хувийн өсөлттэй байна.


Нийт зээлийн үлдэгдлийн 79.7 хувь төгрөгийн, 20.3 хувь валютаар олгогдсон зээл байна. Ихэнх салбаруудад төгрөгийн зээл түлхүү олгогдсон байна. Харин боловсрол, санхүү даатгал, цахилгаан, хий, уур, агааржуулалт хангамж, мэргэжлийн, шинжлэх ухааны салбарт валютын зээл давамгайлж байна.

Тайлант сард банкууд нийт 1 их наяд 389 тэрбум төгрөгийн зээл шинээр олгосон байна. Олгосон зээл өмнөх сараас 74.5 тэрбум төгрөгөөр буюу 5.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 6 дугаар сарын байдлаар нийт 1 их наяд 140 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөн бөгөөд өмнөх сартай харьцуулахад 7.0 хувиар өссөн байна.

Зураг 1. Зээлийн үлдэгдэл



Зураг 2. Зээлийн үлдэгдэл /төгрөг, валютаар/



Зураг 3. Олгосон, төлөгдсөн зээл



¹ Зоос, Хадгаламж банк.


² МИК-д шилжүүлсэн 2.45 их наяд төгрөгийн зээлийн дүн нь банкны салбарын үзүүлэлтээс хасагдаж, бусад санхүүгийн байгууллагын үзүүлэлтэд тусгагддаг.

Олгосон зээлийг валютаар нь авч үзвэл хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын зээлүүд 100 хувь төгрөгөөр олгогдсон байгаа бол мэргэжлийн, шинжлэх ухаан, уул уурхайн олборлолт болон хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагааны салбарт дийлэнх нь гадаад валютаар олгогдсон байна.

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 8.8 байна. Харин салбаруудаар нь авч үзвэл усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын чанаргүй зээл 48.0 хувь, уул уурхай олборлолт 25.7 хувь, худалдааны салбарынх 10.4 хувь, боловсруулах үйлдвэрийнх 17 хувьтай байна.

Нийт чанаргүй зээлийн 21.5 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 20.3 хувийг уул уурхай олборлолт, 16.4 хувийг худалдааны салбарт, 10.1 хувийг үл хөдлөх хөрөнгийн салбарт, 9.3 хувийг барилгын салбарт, 10.2 хувийг бусад гэгдэх салбарт олгосон зээл бүрдүүлж байна.


Зураг 4. Олгосон зээл /төгрөг, валютаар/



Зураг 5. Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь /салбараар/



Зураг 6. Олгосон зээл /салбараар/




Шинээр олгосон зээлийг салбаруудаар ангилан авч үзвэл 31.6 хувийг хэрэглээ, цалин тэтгэврийн зээлд, 17.6 хувийг худалдааны салбарт, 14.6 хувийг уул уурхай олборлолт, 6.6 хувийг боловсруулах үйлдвэрт, 6.5 хувийг үл хөдлөх хөрөнгийн салбарт тус тус олгожээ.

Тайлант сард нийт олгосон зээлийн 39.0 хувийг 1 жил хүртэл хугацаатай зээл, 49.5 хувийг 1-5 жил хүртэл хугацааны зээл, 11.5 хувийг 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай олгогджээ.


Хугацаа хэтэрсэн зээлийг гол салбаруудаар авч үзвэл уул уурхайн салбар 26 хувь, барилгын салбар 12.5 хувь, боловсруулах үйлдвэрт 7.1 хувь, худалдааны салбарт 4.8 хувь, хэрэглээний зээл 1.6 хувьтай байна.

Банкууд чанаргүй зээлээс үүдэж гарах алдагдлаас хэр хамгаалагдсан байгаа эсэхийг тодорхойлдог нөөцийн хүрэлцээний харьцаа (provision coverage ratio)-г салбар бүрээр авч үзвэл захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа³, боловсрол, цахилгаан хий, уур, агааржуулалтын хангамж, уул уурхай, олборлолтын салбарын зээл болон хэрэглээний зээл хүрэлцээтэй түвшинд байгаа бол усан хангамж, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа,

Зураг 7 Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Зураг 8. Чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн зээл /тухайн салбартаа эзлэх хувиар/



Зураг 9. Эрсдэлийн сан болон чанаргүй зээлийн харьцаа



³ Захиргаа болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын эрсдэлийн сан ба чанаргүй зээлийн харьцаа 340.6 хувьтай байна. Зураг 10-т харуулаагүй болно.

Нийт иргэдийн зээлийн үлдэгдлийн 3.6 хувийг чанаргүй зээл эзэлж байна.

Харин иргэдийн ипотекийн зээлийн 3.3 хувь, цалингийн зээлийн 1.9 хувь, бусад зээлийн 3.0 хувь, хэрэглээний зээлийн 2.5 хувь, тэтгэврийн зээлийн 0.3 хувь нь чанаргүй зээл байна.


Тайлант сард иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 19.5 хувь, цалингийн зээл 20 хувь, хэрэглээний зээл 19.6 хувь, бусад зээл 20.8 хувь, тэтгэврийн зээл 17.7 хувьтай байна.

Харин хугацаагаар нь авч үзвэл ипотекийн зээлийн дундаж хугацаа 17.7 жил, цалингийн зээл 3.1 жил, бусад зээл 1.1 жил, хэрэглээний зээл 1.9 жил, тэтгэврийн зээлийн хугацаа 1.7 сарын хугацаатай байна.

Тайлант сарын эцсийн байдлаар ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд нийт 2 их наяд 154 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. ЖДҮ эрхлэх зориулалтаар ААН-д олгосон зээлийн үлдэгдлээс хамгийн өндөр 33.0 хувь буюу 463.5 тэрбум төгрөгийн зээлийг боловсруулах үйлдвэрт, 23.9 хувь буюу 335.7 тэрбум төгрөгийг худалдааны салбарт олгожээ. Харин ЖДҮ эрхлэх зориулалтаар иргэдэд олгосон зээлийн 50.0 буюу 375.4 тэрбум төгрөгийн зээлийг худалдааны салбарт олгосон байна.

ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлийн 14 хувь чанаргүй зээл болжээ.


Зураг 13. Иргэдийн чанаргүй зээлийн хувь /зориулалтаар/



Зураг 14. Иргэдийн зээлийн жигнэсэн дундаж хугацаа


	Зээлийн дундаж хүү /хувь/	Зээлийн дундаж хугацаа /сар/
Ипотекийн зээл	11.4	213.1
Хэрэглээний зээл	19.6	22.7
Цалингийн зээл	20.0	37.4
Тэтгэврийн зээл	17.7	1.7
Бусад зээл	20.8	13.8

Зураг 15. ЖДҮ-ийн зээл /олгосон салбараар/



Салбараар нь авч үзвэл ЖДҮ-ийн зориулалтаар аж ахуйн нэгжид олгосон зээлийн хувьд үйлчилгээний салбарт 26.1 хувь, иргэдэд олгосон зээлийн хувьд барилгын салбарын чанаргүй зээл мөн адил өндөр буюу 24.6 хувьтай байна.

Зураг 16. ЖДҮ-ийн чанаргүй зээлийн хувь



ЖДҮ эрхлэгчдэд олгож буй зээлийн жигнэсэн дундаж хүү болон хугацааг харьцуулахад иргэдэд олгогдож буй үйлчилгээний салбарын зээлийн хүү хамгийн өндөр 23.5 хувь, хугацааны хувьд 23.9 сар байна. Аж ахуйн нэгжийн барилгын салбарын хүү хамгийн өндөр 20.3 хувь, хугацааны хувьд 26.5 сар байна.

Зураг 17. ЖДҮ-ийн зээлийн хүү, хугацаа

